



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11.
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315.
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2022-04-21 № 03/1815
танай _____-ны № _____-Т

**Г САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН
ГАЗАРТ**

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан “Пирамид проект” ХХК-д Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 8.6 дахь заалтын дагуу олгох 18,713,281.50 (арван найман сая долоон зуун арван гурван мянга хоёр зуун наян нэг төгрөг тавин мөнгө) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт..... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  С.БАТБОЛД



080001436

Боловсруулсан:

Хянасан:

Хувь: 2

Огноо: 2022.04.21



8827 30080

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах данснаас барьцаа хөрөнгө олгох жагсаалт

2022.04.21

/төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2022 оны эхний үлдэгдэл	2022 онд нэмэгдсэн орлого	2022 онд олгосон дүн	Одоо олгох дүн	Үлдэгдэл	Гэрээний заалт	Шийдвэр
	Эрх нээлгэх нийт дүн		37,426,563.00	0.00	0.00	18,713,281.50	18,713,281.50		
1	Хожуулын голын эх хүртэлх авто замын засвар, 90 км /Завхан, Тосонцэнгэл сум/	"Пирамид проект" ХХК	37,426,563.00			18,713,281.50	18,713,281.50	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.03.14-ны өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ын 8.6 дахь заалт	Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтад авах ажлын хэсгийн 2019.10.15-ны өдрийн акт, дүгнэлт, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын 2022.04.18-ны өдрийн 1/118 дугаартай албан бичиг


Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн дарга

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч


Д.Фэрлэм

Ч.Ренчиндамба

Н.Баярсайхан


21



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр;
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2018.05.03 № 1-1/2160
танай 2018.04.24 -ны № 05/1798

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА**

Танайхаас ирүүлсэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны "Журам батлах тухай" /Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам/ 49 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3898 дугаарт бүртгэснийг мэдэгдье.



08 1566
Даруул 05.2018



Захиргааны хэм хэмжээ
актын улсын нэгдсэн сан,
2018 оны 03 сарын 14-ны
өдрийн 3892 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Авто замын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг баримтлан Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай.

САЙДЫН ТУШААЛ

Ж.БАТЭРДЭНЭ

Бүртгэлийн дугаар 100
 МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ХУУЛЬ АР СЛЕСЭН ДАЖИЗНЫ ТӨРЛИН ҮСЭГ
 2018 оны 04 сарын 24 ний өдөр

Зам тээврийн хөгжлийн байдлыг
2018 оны 2-дугаар сарын 17-ний өдрийн
12 дүгээр тушаалын хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ,
ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД АВАХ ЖУРАМ 1
5919467
1116126781

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, их засвар хийх инженерийн хийцтэй бүх төрлийн авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад мөрдөнө.

Хоёр. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох

2.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан хуулийн этгээд /цаашид Гүйцэтгэгч гэх/ нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлт гаргахдаа энэхүү журмын 4 дүгээр хавсралтын А хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлж, тухайн авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник технологийн хяналт тавих эрх бүхий Зөвлөх /цаашид Зөвлөх гэх/ -оор хянуулан Захиалагчид хүргүүлднэ.

2.2. Захиалагч авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, шийдвэрлэнэ. Дурдсан хугацаанд хүсэлтийг шийдвэрлээгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг Гүйцэтгэгчид албан бичгээр хүргүүлднэ.

2.3. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг тухайн авто зам, замын байгууламж баригдаж дуусах хүртэлх гэрээнд заасан хугацаагаар олгоно. Барилгын ажил гэрээт хугацаанд дуусаагүйгээс гэрээний хугацаа сунгасан бол зөвшөөрлийн маягтад сунгасан тухай тэмдэглэнэ.

2.4. Зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд барилгын ажил эхлээгүй тохиолдолд тухайн зөвшөөрөл хүчингүй болсонд тооцогдоно. Энэ тохиолдолд Захиалагчид ажил эхлүүлэх хүсэлтийг дахин гаргаж шийдвэрлүүлднэ.

Гурав. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох

3.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил дараах шалтгаанаар 6 сараас дээш хугацаагаар зогссон бол барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажлыг зогсоосон;
- Техник технологийн хяналтын Зөвлөхийн санал дүгнэлтэд үндэслэн Захиалагчийн шийдвэрээр ажлыг зогсоосон.

3.2. Дээрх үндэслэлээр барилгын ажил зогссон бол Гүйцэтгэгч энэхүү журмын 4 дүгээр хавсралтын Б хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлж, ажил зогсоосон шалтгаан, зөрчил дутагдлыг арилгасан тухай эрх бүхий байгууллагын дүгнэлтийн хамт ажил үргэлжлүүлэх


хүсэлтийг Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч ирүүлсэн баримт бичгийг нягталж, шаардлага хангасан бол ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Дөрөв. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах

- 4.1. Авто замын тухай хуулийн 28.1, 28.2-т заасан эрх бүхий байгууллага буюу Захиалагчийн зүгээс авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /цаашид "Ажлын хэсэг" гэх/-ийг томилно.
- 4.2. Гүйцэтгэгч авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлт гаргахдаа энэхүү журмын 4 дүгээр хавсралтын В хэсэгт заасан баримт бичиг, холбогдох материалыг бүрдүүлэн Зөвлөхөөр хянуулж, баталгаажуулна.
- 4.3. Захиалагч хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Ажлын хэсэг ажиллуулах эсэх шийдвэр гаргана. Захиалагч Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилохдоо авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран энэхүү журмын хоёрдугаар хавсралтыг удирдамж болгоно.
- 4.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор ашиглалтад авах объектод очиж ажиллана.
- 4.5. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг хангуулах ажлыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, хяналтын Зөвлөх, Гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна.
- 4.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хуралдаан зохион байгуулах, гишүүдийн ирц бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, гарах шийдвэрийн төсөл боловсруулах, техникийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан архивд хүлээлгэн өгөх ажлыг хариуцна.
- 4.7. Ажлын хэсэг томилсон шийдвэрийн дагуу газар дээр нь ажиллахаар төвлөсөн өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө ажиллах газар, хугацаа, тухайн авто зам, замын байгууламжтай холбоотой ерөнхий мэдээллийг Ажлын хэсгийн нийт гишүүдэд хүргүүлсэн байна.
- 4.8. Ажлын хэсгийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд энэ тухай Ажлын хэсгийн дарга болон нарийн бичгийн даргад газар дээр нь ажиллахаас 1-ээс доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэн байна.
- 4.9. Ажлын хэсгийн зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 4.10. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах тухай Ажлын хэсгийн дүгнэлт гарч, Акт үйлдэж баталгаажуулснаар уг авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулсанд тооцно.

Тав. Ажлын хэсгийн эрх, үүрэг


- 5.1. Ажлын хэсэг нь Авто замын тухай хууль болон бусад хууль, тогтоомж, авто зам, замын байгууламжийн зураг төсөл, стандарт, техникийн баримт бичигт заасан шаардлага, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үүрэгтэй.
- 5.2. Ажлын хэсэг нийт гишүүдийн 90-ээс дээш хувийн ирц бүрдсэнээр ажиллана. Ажлын хэсгийн гишүүн хуралдаанд оролцох боломжгүй бол тухайн гишүүнийг томилсон байгууллагаас орлон ажиллах хүнийг томилно.
- 5.3. Ажлын хэсгийн нийт гишүүдийн санал дүгнэлтийг үндэслэн, дийлэнх олонхийн саналаар эцсийн шийдвэр гаргана. Энэхүү шийдвэр нь "Авто-замын тухай" болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.
- 5.4. Ажлын хэсгийн гишүүд мэргэжлийн чиглэл, ажлын чиг үүргийн дагуу ажиллаж, хариуцсан асуудал тус бүрээр санал дүгнэлтээ танилцуулна. Үүнд:
 - 5.4.1. Авто зам, замын байгууламжийг батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх, гүйцэтгэлийн чанар, ашиглалтын болон



- хөдөлгөөний аюулгүй байдал хангасан эсэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар нарийвчлан шалгах, дүгнэлт гаргах;
- 5.4.2. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт, баталгаажуулалт хийсэн байдлыг шалгах, нягтлах;
- 5.4.3. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын хүрээнд хийгдсэн бусад байгууламж, төлбөр авах цэгийн барилга, суурилагдсан тоног төхөөрөмж, инженерийн нэмэлт шугам сүлжээний ажилд сорилт туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдал, стандартын шаардлага хангасан эсэх зэрэг ажил, үйлчилгээ явуулах, ашиглахад бэлэн эсэхийг шалгах, дүгнэх;
- 5.4.4. Зохих журмын дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх үнэлгээг гарган, ашиглалтад авах Ажлын хэсгийн акт, дүгнэлтэд тусгах;
- 5.5. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажил зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдээгүй буюу чанаргүй хийсэн, стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн шаардлага зөрчсөн бол ашиглалтад авахыг тодорхой хугацаагаар хойшлуулна. Ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагаар хөндлөнгийн дүгнэлт гаргуулна.
- 5.6. Авто замын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн заалтыг ноцтойгоор зөрчсөн тохиолдолд Гүйцэтгэгч, Зөвлөх, зураг төслийн байгууллагад хариуцага тооцох, тусгай зөвшөөрлийн эрх түдгэлзүүлэх, цуцлах зэрэг саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.
- 5.7. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлтийн ажлыг дутуу буюу хууль тогтоомж, стандарт, норм, норматив, дүрэм, зураг төсөл, техникийн нөхцөл шаардлагыг зөрчиж чанаргүй хийсэн, барилгын ажлын явцад Захиалагч болон Зөвлөх, мэргэжлийн хяналтын байгууллагуудаас тавьсан шаардлага, дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд ашиглалтад авахаас татгалзана.
- 5.8. Ажлын хэсэг авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад авах, авто тээврийн хөдөлгөөн нээх шийдвэр гаргаж болно.
- 5.9. Ажлын хэсгийн зүгээс шаардлагатай гэж үзвэл авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдсэн болон ашиглалтын шаардлага, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх талаар нарийвчилсан хэмжилт, иж бүрэн болон хэсэгчилсэн чанар байдлын дүгнэлт гаргах судалгаа хийлгэж болно.
- 5.10. Ажлын хэсгийн гишүүд зураг төсөл, техникийн шаардлагын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах талаар шаардлагатай үүрэг чиглэл өгч, гүйцэтгэлийн биелэлтийг хуралдаанд танилцуулан нэгдсэн зөвшилцөлд хүрсэн тохиолдолд энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулснаар Ажлын хэсгийн шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 5.11. Ажлын хэсгийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хурлын протоколд тэмдэглэж, Гүйцэтгэгч заасан хугацаанд чанартай гүйцэтгэж, биелэлтийг тайлагнах бөгөөд гүйцэтгэлийн чанарт Зөвлөх болон зам хариуцагч байгууллага хяналт тавьж ажиллана.
- 5.12. Ажлын хэсгийн акт баталгаажаагүй, архивын материалыг шаардлагын дагуу бүрдүүлж хүлээлгэж өгөөгүй байхад Гүйцэтгэгч болон Зөвлөхийн эцсийн шатны санхүүжилт олгохыг хориглоно.

**Зургаа. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын
техник технологийн хяналтын Зөвлөхийн эрх, үүрэг**

- 6.1. Зөвлөх нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил бүрэн дууссан тухай мэдэгдэл болон авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлтийг хянаж баталгаажуулан Захиалагчид хүргүүлнэ.



6.2. Барилгын ажлын үе шатны техник технологийн хяналтын болон Захиалагч, мэргэжлийн хяналтын байгууллагаас тавьсан албан шаардлага, Ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Гүйцэтгэгчээр гаргуулж, хянаж баталгаажуулан Ажлын хэсэгт хүргүүлнэ.

6.3. Зөвлөх нь тухайн авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаанд тухайн объектын чанар байдалд гэрээнд заасны дагуу үзлэг хийж, дүгнэлт гаргаж, Захиалагчид ирүүлнэ.

6.4. Гүйцэтгэлийн чанар, технологийн алдаанаас үүссэн эвдрэл гэмтлийг Гүйцэтгэгч засварлах үйл ажиллагаанд хяналт тавьж, чанарыг баталгаажуулна.

6.5. Авто зам, замын байгууламжийн ажил дутуу, чанаргүй хийгдсэнээс Ажлын хэсэг дахин ажиллуулах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг хариуцна.

6.6. Ашиглалтад орсон тухайн барилга байгууламжийн паспорт, картыг Ажлын хэсэг газардээр нь ажиллахаас өмнө Гүйцэтгэгчээр гаргуулж, баталгаажуулсан байна.

Долоо. Гүйцэтгэгчийн үүрэг

7.1. Авто зам, замын байгууламжийг зураг төсөл, стандарт, норм норматив, техникийн шаардлагын дагуу чанартай гүйцэтгэж, Ажлын хэсгийн дүгнэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгана.

7.2. Авто замын тухай хуулиар авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа 3 жил байхаар заасны дагуу Гүйцэтгэгч түүний чанарыг хариуцах, барилгын ажлын технологийн алдаанаас үүдэн гарсан эвдрэл, гэмтлийг өөрийн хөрөнгөөр засварлах баталгаа гаргаж, энэ хугацаанд гүйцэтгэх ажлын гэрээг Захиалагчтай байгуулж, хэрэгжүүлнэ.

7.3. Ашиглалтад орсон тухайн барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг, баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаж, батлагдсан маягтын дагуу замын паспорт, түүр, хоолойн картыг үнэн зөв хөтөлж, цаасан болон цахим хэлбэрээр авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагын архивд хүлээлгэн өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

Найм. Чанарын баталгаат хугацаа, барьцаа хөрөнгө суллах

8.1. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгаат хугацаанд Гүйцэтгэгч, Зөвлөх этгээдүүд тухайн зам, замын байгууламжид илэрсэн барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтлийг бүрэн хариуцна. Ашиглалтын буруугаас болон байгалийн гэнэтийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан эвдрэлийг хариуцахгүй.

8.2. Баталгаат засварын хугацааг Захиалагч эсвэл ашиглалтад оруулах Ажлын хэсгийн дүгнэлт, шийдвэрээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нээсэн өдрөөс эхлэн тооцно.

8.3. Авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад оруулсан тохиолдолд тухайн хэсэгт чанарын баталгаат хугацааг энэхүү журмын 8.2 дахь заалтын дагуу тооцно.


8.4. Чанарын баталгаат хугацаа дууссаны дараа дор дурдсан баримт бичгийг үндэслэн, Захиалагчийн албан ёсны зөвшөөрлөөр барьцаа хөрөнгийг суллана. Үүнд:

8.4.1. Баталгаат засварын хугацаанд хийгдсэн ажлын тайлан

8.4.2. Техник технологийн хяналтын Зөвлөхийн дүгнэлт

8.4.3. Зам хариуцагч байгууллагын зөвшөөрөл.

8.5. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсгийн акт баталгаажсанаар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.



8.6. Ажлын хэсгийн акт баталгаажсанаар Зөвлөхийн болон Гүйцэтгэгчийн барьцаа хөрөнгийн 50 хувийг чөлөөлөх бөгөөд чанарын баталгаат хугацааны эхний 1 жилд уг объектод технологийн эвдрэл илрээгүй тохиолдолд үлдэгдэл барьцаа хөрөнгийн 50 хувийг чөлөөлнө. Чанарын баталгаат хугацаа дуусахад /акт баталгаажсанаас хойш 3 жил/ барьцаа хөрөнгийн үлдэгдлийг бүрэн чөлөөлнө.

Ес. Хүлээх хариуцлага


9.1. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулах үйл ажиллагааны явцад барилгын ажлын талаар худал мэдээлэл өгсөн талууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.


9.2. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үед гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн архивын материалын бүрдэлтэнд хяналт тавьж ажиллах бөгөөд бүрдэл дутуу материал архивд хүлээн авсан тохиолдолд тухайн мэргэжилтэн болон архивын ажилтанд хариуцлага тооцно.

9.3. Энэхүү журмыг зөрчсөн аливаа зөрчил нь Захиргааны, Эрүүгийн, Зөрчлийн тухай, Иргэний хуулийн заалтыг зөрчсөн эсэхийг Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу эрх бүхий хууль хяналтын байгууллага тогтоож, холбогдох хуулийн заалтаар хариуцлага оногдуулна.

9.4. Барилга, байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсгийн гишүүд хууль зөрчиж, алдаатай шийдвэр, дүгнэлтийг санаатай болон санамсаргүйгээр гаргасан нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авилгын эсрэг хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

-оОо-







“ПИРАМИД ПРОЕКТ” ХХК

22 04
20... он ... сар /... өдөр

АВТО ЗАМ, БАРИЛГА УГСРАЛТ, ЗАСВАР ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

№ 22/44

Улаанбаатар хот
Утас: 7711 0788, 9009-9998

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ САНХҮҮ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС – Т

Баталгаа чөлөөлүүлэх тухай:

Манай компани нь 2018 оны 05 дугаар сарын 17- ны өдөр Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын захиалгаар Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Хожуулын голын эх хүртэлх 90 км авто замын хэсэгчилсэн зам, засварын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 2019 оны 10 дугаар сарын 15- ны өдөр захиалагч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулсан болно.

Дээрх зам, засварын ажлын чанарын баталгааны хугацаа дууссан тул зохих журмын дагуу 37,426,563 төгрөгийн баталгааг суллаж өгнө үү.

Холбогдох материалыг хавсаргав.

Хүндэтгэсэн;

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



PYRAMID

МОНГОЛ УРСЫН
ЗАМ, ТЭЭВЭРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ
УХААДЭГ
Бүтээгч нь *0937* *14/11*
Утас: *20200419*
Сарын



**ЗАВХАН АЙМГИЙН
ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

81030 Шумуулгай, Тосонцэнгэл сум

Утас/Факс: 7046-8031

tosontsengel1123@gmail.com

2022.04.18

№

1/118

танай _____ -ны № _____ -г

Санал хүргүүлэх тухай

Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Хожуулын голын эх хүртэлх 90 км авто замын хэсэгчилсэн засварын ажлыг Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын захилгаар “Пирамид проект” ХХК нь 2018 оны 05 дугаар сарын 17-ний өдөр, ЗС-14/2018 дугаартай гэрээг байгуулан 2019 оны 10 дугаар сарын 15-нд байнгын ашиглалтанд хүлээн авсан болно.



Өнгөрсөн хугацаанд ашиглагч байгууллагын зүгээс засварын ажлын чанартай холбоотой ямар нэгэн санал, гомдол гүйцэтгэгч байгууллагад гараагүй бөгөөд уг зам нь хэвийн ашиглагдаж байгаа тул чанарын баталгааг суллахад татгалзах зүйлгүй болно.

ДАРГА  Л.ОДОНТУЯА





БАТЛАВ.



**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ХОЖУУЛЫН ГОЛЫН ЭХ ХҮРТЭЛХ 90 КМ
АВТО ЗАМЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ЗАХИАЛАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД
БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

Дугаар № ЗС-14/2018

2018-05-17

Улиастай сум

Нэг талаас **Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар**, нөгөө талаас **“Пирамид проект” ХХК** дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 05 сарын 17-ны өдөр энэхүү **ГЭРЭЭГ** байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, **зам засварын ажил гүйцэтгэх**, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино...
2. Гүйцэтгэгч нь **ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ХОЖУУЛЫН ГОЛЫН ЭХ ХҮРТЭЛХ 90 КМ АВТО ЗАМЫН ЗАСВАРЫН АЖЛЫГ** 1.497.066.148 [нэг тэрбум дөрвөн зуун ерин долоон сая жаран зургаан мянга нэг зуун дөчин найм] төгрөгөөр дөрвөн зуун ерин долоон сая жаран зургаан мянга нэг зуун дөчин найм] төгрөгөөр гүйцэтгэнэ. Техник хяналтын зардал 23,441,327 төгрөг, Магадлашгүй ажлын зардал 25.871.364 төгрөг Зураг төсвийн үнэ. 22,500,000 төгрөг, зохиогчийн хяналтын зардал 11,720,663 төгрөг хасч тооцоод гүйцэтгэгчид олгоно. Чанарын баталгаанд төсөвт өртгийн 5%-ийг арилжааны банканд **1095 ХОНОГИЙН** хугацаанд тооцох болно. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно .
3. Гэрээний нийт дүн 1,497,066,148 төгрөг.
Улсын төсвийн хөрнгө оруулалтаас 2018онд: 500,000,000 төгрөг санхүүжигдэнэ.
4. Гүйцэтгэгч **“Пирамид проект” ХХК** нь **ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ХОЖУУЛЫН ГОЛЫН ЭХ ХҮРТЭЛХ 90 КМ АВТО ЗАМЫН ЗАСВАРЫН** ажлыг 2018 оны 05 сарын 21-ны өдөр эхэлж 2020 багтаан ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:
 - a. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - b. Гэрээний тусгай нөхцөл;
 - c. Гэрээний ерөнхий нөхцөл;

- d. Ажлын тоо хэмжээ;
- e. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь¹;
- f. Санхүүжилтийн хуваарь;


Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 7. Захиалагч нь санхүүжилтийг тухай жилийн Улсын төсөвт батлагдсан дүнгээр санхүүжилтийн хуваар гарган олгоно.
- 8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
/Д.Өнөрбуян/

[Гарын үсэг]



Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн.
/Ж.Лхагвасүрэн/

Гарын үсэг




Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар
Утас: 99956923, 70462241

Хянасан: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Пирамид проект" ХХК-ний инженер
/Л.Сайхантөр/


[Гарын үсэг]



Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
2-р хороо өнөр барилга 01 тоот

Утас: 90099998, 77110788

Данс: Хас банк 50012394646



Ж.Батцэнгэл

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 2 дугаар хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН АКТ, ДҮГНЭЛТ**

2019 оны 10 сарын 15 -ны өдөр

Дугаар ...

Шумуултай

НЭГ.

1.1. Авто зам, замын байгууламжийн нэр, байршил, хүчин чадал: **Завхан аймгийн Тосонцэнгэл сум Хожуулын эх хүртэл 90 км авто замын хэсэгчилсэн зам засварын ажил**

1.2. Захиалагч байгууллага, нэр, хаяг: **Завхан аймгийн Засаг даргын тамгын газар**

1.3. Техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгчийн нэр, хаяг: **ЗДТГ, ХОХБТХ, “АР СИ ЭС СИ” ХХК**

1.4. Зам хариуцагч байгууллагын нэр, хаяг: **Орон нутгийн зам, Тосонцэнгэл сум ЗДТГ**

1.5. Ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг: **ПИРАМИД ПРОЕКТ ХХК, Улаанбаатар, СБД, 1-р хороо Нарны зам Юнион булдинг В блок 902 тоот**

1.6. Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, зураг төслийн шифр, дугаар: **“АР СИ ЭС СИ” ХХК**

1.7. Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын ХОХБТХэлтсийн даргын шийдвэрээр зохион байгуулсан10...хүний бүрэлдэхүүнтэй комисс нь уг 90 км урт хэсэгчилсэн зам засварын ажлыг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай ПИРАМИД ПРОЕКТ ХХК байгууллагын 2019 оны 10 сарын 10 -ны өдрийн 148 дугаар мэдэгдлийн дагуу 2019 оны 10 сарын 15 -ны өдрөөс 16-ны өдөрт багтаан шинээр барьсан/их засвар/ шинэчлэлтийн ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаж, газар дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийв.

1.7. Энэхүү авто зам, замын байгууламжийг дугаартай зураг төслөөр 2018 оны 05 сараас барьж эхэлсэн бөгөөд 2019 оны 10 сарын 10 -ны өдөр барьж дуусгасан байна.

ХОЁР.

2.1. Энэхүү Завхан аймгийн Тосонцэнгэл сум Хожуулын эх хүртэл 90 км авто замын хэсэгчилсэн зам засварын ажил авто зам, замын байгууламж, холбогдох бичиг, баримт, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр ашиглалтад оруулах комиссоос ШИЙДВЭРЛЭСЭН нь: Байнгын ашиглалтанд хүлээн авахаар шийдвэрлэв.

2.2. Энэхүү авто зам, замын байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж Хожуулы голын халуун усны рашаан сувилалд саадгүй хүрэх, тус багын нутаг дэвсгэрээр зорчиж байгаа зорчигчдыг аюул, осол аваргүй зорчих зориулалтаар ашиглахад БЭЛЭН гэж үзээд захиалагч (ашиглагч) байгууллага болох Завхан аймгийн ЗДТГазар, Тосонцэнгэл сумын ЗДТГазрын мэдэлд 2019 оны 10 сарын 15 -ны өдрөөс ашиглалтад оруулахыг зөвшөөрөв.

2.3. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан

Комиссоос даалгах нь: Байхгүй,

Гүйцэтгэгч байгууллагад: Байхгүй,

1. "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ын Хавсралт 4.В-д заасан баримт бичгүүдийн бүрдлийг хангаж, тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагын архивд 5 хоногийн дотор хүлээлгэж өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх.

2. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгааны 1 жилийн хугацаанд тухайн замд илэрсэн барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтэлийг бүрэн хариуцах.

Зам хариуцагч (ашиглагч) байгууллагад:

1. "Авто замын тухай" хуулийн 27.3-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн паспорт, картыг хянаж, хүлээн авч, бүртгэл мэдээллийн санд баяжилт хийж, холбогдох мэдээллийг жил бүрийн тогтоосон хугацаанд авто зам эзэмшигчид хүргүүлж байх;

2. "Авто замын тухай" хуулийн 23.3.-т заасны дагуу чанарын баталгаат хугацаа дууссанаас хойшхи авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, арчлалт, засварын ажлыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

3. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, барилга байгууламжийн бичиг, баримтын жагсаалтыг хавсаргав.

ГУРАВ. АКТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ


Завхан аймгийн Тосонцэнгэл сум Хожуулын эх хүртэл 90 км авто замын хэсэгчилсэн зам засварын ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Комиссын дарга:

Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын ХОХБТХ-ийн дарга:

Нарийн бичгийн дарга: ЗДТГ –ын ХОХБТХ –ийн ДБ хариуцсан мэргэжилтэн:



Ж.Батцэнгэл

Х.Дэлгэрдалай

21000101 5830227


Завхан аймгийн Тосонцэнгэл сум Хяналтын эх хүртэл 90 км авто замын хэсэгчилсэн зам засварын ажлын ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

КОМИССЫН БҮРЭГЛЭХЛЭГ

Гишүүд: ЗДТ-ын ДБХХэлтсийн БХБГ –ын дарга:

 Т.Пүрэвжав


Завхан аймгийн Иргэдийн хяналтын авто замын хяналтын улсын байцаагч :

 Б.Түдэвпунцаг

Тосонцэнгэл сумын Ирэгдийн хурлын дарга :

Н.Батдорж

Тосонцэнгэл сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн автын байцаагч




Б.Жадамба

Тосонцэнгэл сум дахь Онцгой байдлын хэлтсийн дарга:

И.Амартүвшин

Тосонцэнгэл сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч:




Г.Бямбарагчаа

АР СИ ЭС СИ ХХК –ны зургийн инженер:

 Э.Баярцэнгэл

ПИРАМИД ПРОЕКТ ХХК –ны гүйцэтгэх захирал:

ПИРАМИД ПРОЕКТ ХХК –ны ерөнхий инженер



Наранбаатар

Гэрэлт –Од

Тайлбар: Энэхүү хуудсанд комисст ажилласан гишүүдийн нэр багтаагүй тохиолдолд дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичихдээ дээр нь тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.